


## “БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-Н 2022 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2022.12.09

Улаанбаатар хот

**1. Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:**

Туршилтын 150 га талбайгаас 2022 оны 05 дугаар сарын эхний 5 хоногт хөрсний үржил шимийн үзүүлэлт, тариалалт хийсэн олон наст ургамлын ургалтын байдлыг харгалзан 10 га талбайг сонгон авч 1 га-д 10 тн нормоор тооцож компост бордоо болон бууцаар бордох ажлыг хийсэн.




Дараа жил туршилтын талбайгаа нэмж бордоход зориулж фермийн ойролцоох малчин өрхүүд болон өөрсдийн үнээ, малаас гарсан өтөг бууцыг цуглуулж 50 тонн органик бордоо бэлдсэн.



Техник, тоног төхөөрөмжийн урсгал засварын төлөвлөгөө боловсруулан, батлуулж, төлөвлөгөөт хугацаанд тракторын турбин болон гидрийн механизмын гэмтлийг оношлон, засварын ажлыг амжилттай гүйцэтгэсэн. Мөн хөрс боловсруулах болон үрлэгээний ажилд ашиглах бүх тоног төхөөрөмжийн урсгал засварын ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

1 аж ахуйн нэгж, 4 иргэний захиалгын дагуу "Газар тариалангийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулан газар хагалах, хөрс боловсруулах, хадлангийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Туршилтын талбай болон ногооны 5 га талбайгаас нийтдээ 116 боодол буюу 38 тонн хуйлсан ногоон тэжээл хураан авсан.



**2. Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий "Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах зорилтын хүрээнд хийсэн ажлууд:**

Тайлангийн хугацаанд 20 үнээ тугалж, 20 тугал хүлээн авсан. Фермийн байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж, гэрээт малын эмчид үзүүлэн, эрүүл мэндийн үзлэг болон вакцинжуулалтад бүрэн хамруулж ажиллаж байна. Нийт 7,5 тонн литр сүү бэлтгэн, нийлүүлсэн.

Малын удмын сан, НХХААГ, "Нутаг академи" ТББ-тай хамтран "Бод малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх" сертификаттай сургалтыг байгууллагын 90 үхрийн фермийн аж ахуй дээр зохион байгуулсан.

Хөдөө орон нутаг болон нийслэлээс тус сургалтанд хамрагдсан 27 иргэнд байгууллагын зүгээс нэвтрүүлж байгаа дэвшилтэт техник, технологийн талаар болон малын өтөг бууц, хүнсний био хог хаягдлыг ашиглан компост бордоо хийж бэлчээр, хадлангийн талбайг бордож, хөрсний үржил шимийг сайжруулж байгаа үр дүнг танилцуулж, зөвлөгөө өгсөн.


Мөн Фермер Г.Туул тус сургалтанд амжилттай хамрагдан сертификат гардан авсан.



"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон хот-Иргэний оролцоо" хаврын мод тарих аяны хүрээнд байгууллагын албан хаагчид 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Хан-Уул дүүргийн 14 хороо, Айдсын ам /7 га/-ны талбайн хуваарьт газраа 24 ш хайлаас мод тариалав. Үйл ажиллагаанд оролцохдоо Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохжилт ногоон байгууламжийн гүйцэтгэл хяналтын хэлтэсээс зөвлөмж авч хамтран ажилласан болно.





НИЙТЛЭГ ЧИГ ТҮРЭГ ИХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДАГА ЧИГЛЭЛЭЭР:  
Байгууллагын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, сургалтын болон нийгмийн багаланг  
хөгжих төлөвлөгөөг Боловсруулах Байгуулсан



Мөн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны захиалгаар модны тарьц суулгац бэлдэх мод үржүүлгийн газар байгуулах ажлын хүрээнд Хужирбуланд 5 га атаршсан талбайг хагалж, хөрс боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.



Фермийн хашаан дахь мод бут ногоон байгууламжийн арчилгаа усалгаа болон тохижилт, цэвэрлэгээний ажлыг тухай бүрд нь гүйцэтгэж ажилласан.



### НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №1 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА ЧИГЛЭЛЭЭР:

Байгууллагын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, сургалтын болон нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулсан

“UB.ERP.EDOC” системийн ашиглалт сайжирч, байгууллагын албан хаагч өөрт холбогдолтой албан бичигтэй танилцаж, бичгээ цаг тухай бүр нь шийдвэрлэн ажиллаж байна.

Албан хаагчдын өргөдөл гомдлыг тухай бүрд нь бүртгэн оруулж, хуулийн хугацаад бүрэн шийдвэрлэн ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 3, шинээр ажилд орсон 3, өөр албан тушаалд сэлгэн ажиллаж байгаа 1 албан хаагч ажиллаж байна. Бусад ажилтнуудын хувьд тогтвор суурьшилтай ажиллаж байна.

#### **НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №2. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ БОЛОН ИЛ ТОД БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Байгууллагын <http://bmt.ub.gov.mn/> Web хуудсыг тухай бүр шинэчлэн цаг үеийн мэдээ мэдээлэл болон байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг шинэчлэн оруулж байна.

Ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд байгууллагын Web хуудсанд ажлын байрны зарыг тухай бүр оруулж хэвшсэн.

#### **НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №3. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР:**

UB.ERP” системд тавигдсан өдөр тутмын мэдээг цаг алдалгүй албан хаагчдад хүргэж, системд бүртгэлтэй албан хаагч нар өдөр тутмын мэдээ мэдээлэлтэй танилцаж судалгаанд цаг алдалгүй идэвхитэй оролцож ажиллаж байна.

#### **НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №4 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

“Улаанбаатар марафон 2022” олон улсын гүйлтийн тэмцээнд хамт олноороо идэвхитэй оролцож, нярав Б.Дорждэрэм 5 км-ийн зайд 38 дугаар байрт шалгарсан.



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн Архивын газраас зохион байгуулагдсан нийт 5 удаагийн сургалтанд Хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн, Агорномич, Санхүү төрийн сангийн хэлтэсээс зохион байгуулсан 2 сургалт, Нийслэлийн өмчийн харилцааны газраас зохион байгуулсан 1 сургалт, Нийслэлийн төр захиргааны авто

баазаас явуулсан онлайн сургалтанд нягтлан бодогч Ц.Мөнхдөл нар тус тус хамрагдсан байна.

Энэ онд хийгдсэн өмчийн улсын үзлэг тооллогын бэлтгэл ажлыг ханган амжилттай зохион байгуулан дүн мэдээ, тайланг батлагдсан маягтын дагуу бөглөн програмд бүртгүүлэн дээд шатны байгууллагад мэдээлэн ажилласан.

СБД-ийн 19-р хорооны хэсгийн ахлагч нар болон Нийслэлийн мэргэжлийн хяналтын нэр бүхий байцаагийн хамтаар 2022 оны 01 дүгээр сард сайжруулсан түлшний хэрэглээнд хяналт хийж, айл өрх, аж ахуйн нэгжүүдээр орж, зөвлөгөө өгч ажилласан.

#### **НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №5. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2022 оны төсвийн жилд байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 348.9 сая төгрөг батлагдсан. Хагас жилийн тодотголоор 329,7 сая төгрөг болон буурсан. Тайлант жилд 315,2 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 312,0 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Тайлант жилд орлогын төлөвлөгөө 14,2 сая төгрөг байхаас биелэлт 100 хувьтай байна.

Түлш шатахуун, багаж хэрэгсэл худалдан авах зардал хүрэлцэхгүйн улмаас тэвчиж болох гэрэл цахилгааны зардалд хэмнэлт гарган Санхүү төрийн сангийн хэлтэст 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 25 тоот албан бичгээр хүсэлт гарган эдийн засгийн ангилал хооронд зохицуулалт хийлгүүлсэн.

2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг биелүүлэн даган мөрдөж байгаа бөгөөд биелэлтийг тайлагнан Нийслэл дэх төрийн аудит, Нийслэл аудит ХХК, Санхүү төрийн сангийн хэлтэст албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

Нийслэлийн дотоод аудитын газраас байгууллагын 2020,2021,2022 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн бөгөөд зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан биелэлтийг ханган ажиллаж байна.

#### **НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №6. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:**

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг байгууллагын Дарга болон төслийн Менежер хариуцан ажиллаж байна.

#### **НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №7 АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2022 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын хэмжээнд нийт албан бичийг хүлээн авч бүртгэн, удирдлагад танилцуулан, холбогдох мэргэжилтэнд шилжүүлж, шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Албан бичгийг **Erp.Edoc** системд бүртгэсэн байдлаар авч үзвэл:

- Байгууллагаар бүртгэсэн 4
- Системээр бүртгэгдсэн 110,
- Байгууллагад нийт ирсэн бичиг 114

**Үүнээс:**

- Хариутай албан бичиг 45
- Хугацаандаа шийдвэрлэгдсэн 42
- Хугацаа хоцроож шийдвэрлэсэн 2
- Судалж байгаа төлөвтэй албан бичиг 1
- Хариугүй албан бичиг 69

Албан бичгийг хугацаа хоцроож шийдвэрлэсэн буюу албан бичгийн шийдвэрлэх хугацааг сунгуулсан албан бичиг байхгүй.

Албан бичгийн шийдвэрлэлийн хувь 98.19%, албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног, ажлын 6 хоногт багтаан шийдвэрлэгдэж, албан бичгийн шийдвэрлэлтийн хяналтын тухай хянан баталгаажуулж ажиллаж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын хэмжээнд 4 өргөдөл гомдлыг бүртгэн хүлээн авч удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтанд шилжүүлж, ажлын 5 хоногт багтаан бүрэн шийдвэрлэж ажилласан.

**НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №8 АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Байгууллагын 2022 оны ХХНЖ-ыг батлуулж, 2021 онд байгууллагад үүссэн цаасан суурьтай 70 жил хадгалах 5, байнга хадгалах 39, түр хадгалах 23 баримтыг архивт бүрэн хүлээн авч дууссан.


Үүссэн цаасан болон цахим баримтыг "UB ERP" нэгдсэн системийн "Archive edoc"-д <https://arch.ulaanbaatar.mn/> бүрдүүлэлт хийж, хянан баталгаажуулалт хийсэн.

ХЯНАСАН:  
ДАРГА:



Н.УУГАНБАЯР

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР:



Г.ПҮРЭВСҮРЭН